

2024 он 09 сар 10 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох тухай

Говь ХК-ийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсгийг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Говь ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК-ийг дахин сонгосугай.
2. “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК-тай байгуулах гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д зөвшөөрсүгэй.
3. Хөндлөнгийн аудитын дүгнэлт, захидлыг хүлээн авч, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороонд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д үүрэг болгосугай.
4. “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК-тай байгуулах гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/, Санхүү бүртгэл хариуцсан захирал /Д.Содгэрэл/ нарт тус тус үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА.



Д.ГЭРЭЛМАА

2024 он 09 сар 10 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөх тухай

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Э.Пүрэвлхам нь чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн тул Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77-р зүйлийн 77.5, 80 дугаар зүйлийн 80.2, Говь ХК-ийн дүрмийн 6.2-р зүйлийн 6.2.8, 6.2.14 дэх заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүн Э.Пүрэвлхам-ыг 2024 оны 09-р сарын 10-ны өдрөөр тасалбар болгон Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн тухай холбогдох дүрэм журмын дагуу олон нийтэд мэдээлэл хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



Д.ГЭРЭЛМАА

2024 он 09 сар 10 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77-р зүйлийн 77.5, 77.6, 80 дугаар зүйлийн 80.2, Говь ХК-ийн дүрмийн 6.2-р зүйлийн 6.2.8, 6.2.14 дэх заалтыг тус тус удирдлага болгон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнийг түр томилох тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Б.Цээням-ыг 2024 оны 09-р сарын 10-ны өдрөөс эхлэн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүнийг сонгох хүртэлх хугацаанд Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилсугай.
2. Шинээр томилогдсон ТУЗ-ийн хараат бус гишүүн /Б.Цээням/-д Компанийн тухай хууль, холбогдох хууль дүрэм журмын дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүний үүргээ хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгосугай.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн тухай холбогдох дүрэм журмын дагуу олон нийтэд мэдээлэл хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



Д.ГЭРЭЛМАА